

“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ-ХАРИУЦЛАГАТАЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА” НЭРЭМЖИТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТ
(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024.12.02		Өлгий хот		
№	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Үнэлгээ
Нэг. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхижуулах чиглэлээр				
1.1.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг Газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах		Аймаг, сумын Засаг даргыг Газрын багц хуулиуд, Хот байгуулалт, Барилгын тухай болон бусад хууль тогтоомжуудад заасан эрх, үүргийн талаарх мэдээллийг өгч, мэргэжил, арга зүйн удирдлагаар байнга ханган ажиллаж байна. Шинээр аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгчид, аймгийн удирдлагуудад салбарын хууль тогтоомж, газрын болон хот байгуулалт, барилгын чиглэлийн төлөвлөлтийн баримт бичгүүд, тэдгээрийн ач холбогдол, газрын удирдлагын нэгдсэн цахим системүүдийн тухай дэлгэрэнгүй сургалт өгч ажиллав.	100
1.2.	Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг Газрын тухай хууль, журмын дагуу цахимаар зохион байгуулж, ялагчид газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх		Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу Засгийн газрын тогтоолоор баталсан жагсаалтаар тухайн оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар тогтомол газрын цахим биржээр дамжуулан зохион байгууллаж байна.	100
1.3.	Монгол Улсын Засгийн газраас баталсан эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ байршил, зориулалтад нийцүүлэн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах		Газар олголтыг Монгол Улсын Засгийн газраас баталсан эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ байршил, зориулалтад нийцүүлэн иргэдээс цахимаар хүсэлтийг хүлээн авч газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдэрлэн ажиллаж байна.	100
1.4.	Иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой хүсэлтийг цахимаар хүлээн авч холбогдох хуулийн хугацаанд шийдвэрлэх		2024 оны 01-сарын 1-ээс эхлэн аймгийн хэмжээнд 3145 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн.	100
1.5.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хууль зүйн үндэслэл бүхий хариуг өгч эцэслэн шийдвэрлэх		Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2024 онд 139 өргөдөл, гомдол ирсэн. Өргөдөл, гомдлын хариуг	100

			хуулийн хугацаанд өгч шийдвэрлэсэн.	
1.6.	Газрын харилцааны салбарын ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдгээрийн нийгмийн баталгааг дэмжих, мэргэшүүлэх, ур чадварыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх		Газрын харилцааны салбарын ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ба “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд албан хаагчдын 2024 оны цалин, нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоож, улирал бүр ажлын үр дүнгээр урамшуулал, буцалтгүй тусламж, шинээр хүүхэдтэй болсон албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгох зэрэг ажлууд тухай бүрт хийгдэж, Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч суралцаж байна.	100
1.7.	Албан хаагчдын тоног төхөөрөмж, ашиглах нөхцлийг сайжруулах тал дээр орон нутгийн байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх		Албан хаагчдын тоног төхөөрөмж, ажиллах нөхцөлийг сайжруулах үүднээс орон нутгийн зүгээс нэг суурин, нэг зөөврийн компьютерыг шийдвэрлүүлж, хүлээн авсан. Мөн аймгийн удирдлагуудад асуудал болгон тавьж 8 сумын газрын даамлыг цоо шинэ мотоциклоор хангаж, унаатай болгосон. Ингэснээр газрын даамлууд иргэдэд түргэн шуурхай хүрч ажиллах нөхцөл бүрдэж хээрийн судалгаа хийх, гарсан маргааныг газар дээр очиж шийдвэрлэх боломж нь илүү сайжарсан.	100
1.8.	Улсын болон улсын ахлах байцаагч нарын зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаанд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль дүрэм зөрчсөн зөрчил, дутагдлыг гаргуулахгүй байх, зөрчлийн хэрэг, гомдлыг шалган шийдвэрлэх ажиллагаанд тавих удирдах албан тушаалтны хяналтыг сайжруулах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг удирдах болон хариуцах эрх бүхий албан тушаалтны мэдлэг, ур чадвар, хариуцлагыг өндөржүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээг авч ажиллах		Тус газарт улсын 3 байцагч ажилладаг. Газрын даргад 2024 оны 07 дугаар сард Улсын ахлах байцаагчийн эрх олгогдсон. Тэдгээрийн зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаанд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль дүрэм зөрчсөн зөрчил, дутагдлыг гаргуулахгүй байх, зөрчлийн хэрэг, гомдлыг шалган шийдвэрлэх ажиллагаанд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажиллаж байна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг удирдах болон хариуцах эрх бүхий албан тушаалтны мэдлэг, ур чадвар, хариуцлагыг өндөржүүлэх талаар дэд газрын болон Прокурорын газраас зохион байгуулсан сургалтад хамруулсан.	100
Хоёр. Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг чангатгах чиглэлээр				
2.1.	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн		Төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүрийн 02-нд Ерөнхий	100

	тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад журам, заавар болон тус газрын НББ-ийн бодлогын баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хуулийн хугацаанд холбогдох тайлан, мэдээг хүргүүлэн ажиллах		газарт, нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 05-ны хүртэл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст, татварын тайланг улиралд нэг удаа дараа сарын 20-ны хүртэл хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, тус тус хүргүүлэн ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар шилэн дансны мэдээлэлд нийт 171 мэдээлэл оруулах байсан ба бүх мэдээллийг хугацаанд нь оруулсан.	
2.2.	Батлагдсан төсвийн зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулах, авлага, өглөг үүсгэхгүй, санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллах		Төсвийн зардлыг зориулалтын дагуу, хэмнэлттэй зарцуулж байна. Оны эцэст ямар нэгэн өглөг, авлага гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна.	100
2.3.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүжилтийг цаг тухайд нь олгох		Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгө худалдан авахад хуулийн дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байна.	100
2.4.	Тус газрын харъяа байгууллагуудын НББ-ийн онлайн программын шинэчлэлтийг 2024 онд нэвтрүүлэх ажлыг нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлэх тул батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэж, санхүүгийн хяналтыг сайжруулах		НББ-н онлайн програмыг 2024 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Төсвийн хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэж, програмын үнийг нийлүүлэгч компанид шилжүүлсэн болно.	100
2.5.	Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах		2023 оны Санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, 2024 онд уг алдааг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллав.	100
Гурав. Геодези, зураг зүйн чиглэлээр				
3.1.	Орон нутгийн төсвөөр хийгдэж буй газар зүйн нэрийн тодруулалтын ажил, том масштабын байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний зураглал хийх ажлын явц, үр дүнд хяналт тавих, гарсан алдаа зөрчлийг арилгуулах		2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баян-Өлгий аймгийн Алтай, Толбо, Улаанхус суманд “Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээлийн сан бүрдүүлэх ажил” хийгдэж байна. Тус ажлын гүйцэтгэгчээр Геодезийн тусгай зөвшөөрөлтэй “Геомэл” ХХК ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл Алтай сум 70%, Толбо сум 95%, Улаанхус сум 80%-тай байна. 2024 оны байдлаар том маштабын байр зүйн зураг, инженер шугам сүлжээний ажил хийгдээгүй байгаа.	100
3.2.	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төсөл,		Олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд Өлгий сумын 7-р	100

	хөтөлбөрийн хүрээнд хийж буй геодези, зураг зүйн ажилд хяналт тавих, хийгдэж байгаа ажлуудыг давхардуулан хийхгүй байхад анхаарах		багийн нутаг дэвсгэрт 42 га талбайд байр зүйн зураг хийгдсэн. Мөн Ногооннуур сумын төвд хил хамгаалах байгууллагын чиглэлээр нэг GNNS-ийн станци суурилагдсан. Эдгээр ажлуудад хяналт тавьж ажилласан байна.	
Дөрөв. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр				
4.1.	Аймаг, нийслэлийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршил, талбайн хэмжээг улирал тутамд бүртгэн зураглаж, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх		Аймаг, сумын хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршил, талбайн хэмжээг бүртгэн зурагласан. 2024 оэд 513,55 га газарт хохирол учруулж урд оныхоос 29,84 га газраар нэмэгдсэн байна. Нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 47,98 га-д Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан. Үүнд: ➤ Алтай сум 10,44 га. Үүнээс: ▪ Хот тосгон бусад суурин газар ✓ Ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 10,44 га. Орон нутгийн төсвөөс 20,0 сая төгрөг ➤ Баяннуур сум 3,06 га. Үүнээс: ▪ Хот тосгон бусад суурин газар ✓ Мод, бут, сөөг тарьсан 1,56 га Хувийн хэвшилээс 3,0 сая төгрөг ✓ Ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 1,5 га. Орон нутгийн төсвөөс 1,7 сая төгрөг ➤ Бугат сум 13,48 га. Үүнээс: ▪ Хот тосгон бусад суурин газар ✓ Ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан 3,69 га, Хувийн хэвшилээс 45,0 сая төгрөг ✓ Ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 9,79 га, Хувийн хэвшилээс 47,0 сая төгрөг ➤ Ногооннуур сум 13,01 га. Үүнээс: ▪ Хот тосгон бусад суурин газар ✓ Ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан 8,63 га Хувийн хэвшилээс 36,0 сая төгрөг	100

			✓ Ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 4,38 га Орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөг ➤ Улаанхус сум 2,12 га. Үүнээс: ▪ Хот тосгон бусад суурин газар ✓ Ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан 0,38 га Хувийн хэвшилээс 2,0 сая төгрөг ✓ Ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 1,74 га Хөгжлийн албан ёсны тусламжаас 280,0 сая төгрөг ➤ Өлгий сум 6,97 га. Үүнээс: ▪ Хот тосгон бусад суурин газар ✓ Ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан 4,0 га Орон нутгийн төсвөөс 15,0 сая төгрөг Ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 2,97 га Хувийн хэвшилээс 50,0 сая төгрөгөөр тус тус нөхөн сэргээлт хийж арга хэмжээ авсан.	
4.2.	Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, бэлчээрийн биомасс, даацыг тодорхойлж, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд ашиглах		Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, бэлчээрийн биомасс, даацыг байгалийн бүс, бүслүүрийн болон аймгийн хэмжээнд тодорхойлж зурагласан. Тус ажлын үр дүнг тухайн жилийн газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд тусгаж, арга хэмжээ авч ажиллах талаарх чиглэлийг газрын даамал, сумын удирдлагуудад хүргэн ажиллаж байна.	100
4.3.	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа бэлчээрийн фото мониторингийн цэгт хээрийн судалгааны ажлыг бүрэн хийж гүйцэтгэхэд дүүрэг, сумын Засаг дарга нартай хамтран ажиллах, хээрийн судалгааны үр дүнг чанартай боловсруулж, Газрын мониторингийн цахим системд үр дүнг оруулж, бэлчээрийн газрын төлөв байдлыг тодорхойлох, бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд суурь		Аймгийн нутаг дэвсгэрт байгаа бэлчээрийн фото мониторингийн 327 цэгт хээрийн судалгааны ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Уг ажлыг хэрэгжүүлэхд сумдын Засаг дарга нартай хамтран ажилласан. Хээрийн судалгааны үр дүнг чанартай боловсруулж, Газрын мониторингийн цахим системд үр дүнг бүрэн оруулж дуусгасан. Энэ ажлын үр дүнгээр бэлчээрийн газрын төлөв байдлыг тодорхойлох, бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд суурь мэдээлэл болгон ашиглах	100

	мэдээлэл болгон ашиглаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, малчид, олон нийтийг нээлттэй мэдээллээр хангаж ажиллах		талаар тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, малчид, олон нийтийг нээлттэй мэдээллээр ханган ажиллаж байна.	
Тав. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр				
5.1.	Аймгийн ГЗБЕТ-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулж ажиллах		Аймгийн ГЗБЕТөлөвлөгөөг 2022 оны 78 дугаар тогтоолоор батлуулж үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллах 98 заалт бүхий төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр аймгийн Засаг даргын орлогчоор батлуулсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны биелэлтийг 2024 оны 01-р сарын 10-ны өдөр ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн.	100
5.2.	Аймгийн хэмжээнд эрх бүхий байгууллагаар батлагдсан болон боловсруулагдаж байгаа хот байгуулалтын баримт бичгүүдийг ГЗБ, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэх, цахим системд бүртгэгдсэн хот байгуулалтын баримт бичгийн хавсралт материал, төлөвлөлтийн орон зайн зураглалын мэдээллийг бүрэн зурагласан эсэхийг нягталж байх		Бохир ус дамжуулах хоолойн хамгаалалтын бүс 80, Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс 28, Усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс 2, Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас 4, 400 мм хүртэл голчтой газар дээр нь ил байрласан дулааны шугамын хамгаалалтын бүс 28, 400 мм хүртэл голчтой газар доорх байрласан дулааны шугамын хамгаалалтын бүс 1728, Цэвэр ус дамжуулах хоолой хамгаалалтын бүс 2227, холбооны шугамын хамгаалалтын бүс 1211 г.м нийт 11488 хамгаалалтын бүс, зурвас газрыг 2021-16-083-4388 дугаартай төсөл үүсгэж газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулсан. Аймгийн хэмжээнд өмнө нь эрх бүхий байгууллагаар батлагдсан хот байгуулалтын баримт бичгүүдийг ГЗБ, хот төлөвлөлтийн цахим системд орсуулсан. 2024 онд Цэнгэл, Улаанхус сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгосон мэдээллийг ГЗБ, хот төлөвлөлтийн цахим системд оруулахыг гүйцэтгэгчээс шаардан ажиллаж байна. Ногооннуур, Буянт сум болон Цагааннуур чөлөөт бүсийн ХЕТ боловсруулагдаж байна.	100
5.3.	Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн ГЗБТ-г аймаг, нийслэлийн ГЗБЕТ, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулах, хуулиар тогтоосон хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын		Аймгийн төв талбайд “Хариуцлагатай газрын харилцаа” сэдвийн доор нээлттэй хаалганы өдөрлөгийг 05-р сарын 20-ний өдөр зохион байгуулсан. Мөн сумын тухайн жилийн ГЗБТ-г аймгийн ГЗБЕТ, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн	100

	бүсийг зөрчихгүйгээр хээрийн судалгаа, хэмжилт зураглалыг бүрэн хийж төлөвлөхөд анхаарч холбогдох мэргэжилтнүүд болон газрын даамлуудыг мэргэжил, арга зүйгээр тогтмол хангах, орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийг ГЗБ-ын чиглэлээр хийгдэж байгаа ажлын талаарх нээлттэй мэдээллээр ханган ажиллах		ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулах, хуулиар тогтоосон хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүсийг зөрчихгүйгээр хээрийн судалгаа, хэмжилт зураглалыг бүрэн хийж төлөвлөх талаар холбогдох мэргэжилтнүүд болон газрын даамлуудыг мэргэжил, арга зүйгээр хангах сургалт зохион байгуулсан. Аймаг, сумын удирдлагуудад салбарын хууль тогтоомж, газрын болон хот байгуулалт, барилгын чиглэлийн төлөвлөлтийн баримт бичгүүд, тэдгээрийн ач холбогдол, газрын удирдлагын нэгдсэн цахим системүүдийн талаар тогтмол мэдээллээр ханган ажилладаг.	
5.4.	Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн ГЗБТ-г Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “ГНС-ийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” 110 дугаар тогтоолын 2.1-т заасны дагуу ГНС-ийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан нэгж талбар бүрээр төлөвлөх		Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас саналыг авч, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд нэгж талбар бүрээр оруулан төлөвлөж байна.	100
5.5.	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдээгүй сумдыг төлөвлөлтийн баримт бичигтэй болгох ажлыг зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, дүгнэлт гаргах		Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах талаар аймаг, сумдын удирдлагуудыг мэдээ, мэдээллээр хангаж 2024 оны төсөвт 5 сумд шинээр хийх 125,0 сая төгрөгийн төсвийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар батлуулсан. Сумын төвийн суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдад шинээр газар олголт хийх боломжгүй болсонтой холбоотой уг төлөвлөгөөг сумын төвийн суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болгож нэршлийг өөрчилсөн.	100
5.6.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн талаар 2023 онд гарсан маргааныг орон нутагтаа шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, иргэд, олон нийтийг хилийн цэсийн талаарх үнэн бодит мэдээллээр хангаж ажиллах		2023 онд Баян-Өлгий аймагт хилийн цэстэй холбоотой ямар нэгэн маргаан гараагүй талаар ГХБХБГазрын даргын 2023 оны 526 дугаар албан бичгээр ГЗБГЗЗБГ-т хүргүүлсэн.	100
Зургаа. Газрын кадастрын мэдээллийн системийн чиглэлээр				
6.1.	ГНС-ийн удирдлагын нэгдсэн цахим системийн ГКЦС-д нэгж талбарын цахим хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах, хувийн		Аймгийн хэмжээнд өмчлөлийн 1594 нэгж талбарын цаасан болон цахим хувийн хэргийг бүрдүүлж холбогдох хууль журмын дагуу аймгийн газрын албаны архивт татан	100

	хэргийг холбогдох хууль, “Нэгж талбарын хувийн хэргийг хөтлөх журам”-ын дагуу үнэн зөв, гүйцэд бүрдүүлэх ажлыг зохион байгуулах		төвлөрүүлсэн. Мөн 2024 онд нийт 886 нэгж талбар үүсгэж цахим архивыг үнэн зөв оруулж, цаасан хувийн хэргийг цаг тухайд хавтаслаж байгууллагын архивт хүлээлгэн өгч байна.	
6.2.	Газар эзэмших гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламж байгуулах, хөрсний бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байгаа байдалд дүгнэлт өгч илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах /тариалангийн талбай, уул уурхай гэх мэт/		Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авах, кадстрын зураг авах, гэрчилгээ шинэчлэх зэрэг газартай холбоотой үйлчилгээ авч буй иргэдийн газарт зөрчил байгаа эсэхийг нэг бүрчлэн шалган ажиллаж байгаа ба хашаагаа сунган илүү газар ашиглаж байгаа 31 иргэнд хугацаатай мэдэгдэх хуудас өгч нийт 40 нэгж талбарын зөрчлийг арилгуулан ажилласан байна.	100
6.3.	Egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэл сурталчлах, танилцуулах арга хэмжээг зохион байгуулах, газар эзэмших, өмчлөх, ашиглах талаарх хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх		2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр аймгийн төв талбайд “Газрын харилцааны салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ой, газрын харилцааны ажилтны өдөрлөг”-тэй холбоотой нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр иргэдэд egazar.gov.mn цахим сайтыг ашиглан шинээр газар эзэмших хүсэлт илгээх, газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг авах зэрэг газартай холбоотой 17 төрлийн үйлчилгээг цахимаар хэрхэн авах боломжтой талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажиллав. Мөн энэ талын ерөнхий газраас хийсэн сургалт, сурталчилгаа, мэдээллийг орон нутгийн иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол дамжуулан хүргүүлж байна.	100
6.4.	Эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж, ГКС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нөхөн бүрдүүлэх арга хэмжээг эцэслэн дуусгах		2024 онд аймгийн хэмжээнд 200 гаруй иргэн ААНБ-ын газрын гэрчилгээг нөхөн бүртгэж мэдэллийн санд оруулсан. Мөн газартай холбоотой гарсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн цаг тухайд нь бүртгэж, газрын гэрээ гэрчилгээ, кадастрын зургийг цахим системээс өөрсдөө гөргөж авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	80
6.5.	Газрын харилцааны цахим үйлчилгээний Киоск машиныг бүх сум, дүүрэгт байршуулан хэрэглээнд арга хэмжээг зохион байгуулах		2024 онд дотоод нөөц боломжинд тулгуурлан шинээр 1 киоск төхөөрөмж нэмж авч, аймгийн нэг цонхны үйлчилгээний төвд байршуулсан. Нийт 2 киоск төхөөрөмжөөр иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.	100
6.6.	Газрын харилцааны цахим үйлчилгээний Киоск машинаар дамжуулан газартай холбоотой		2023 оны 12 дугаар сард холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж 2024 оны 3 дугаар сараас эхлэн Киоск	100

	үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй үзүүлэх, үйлчилгээний хураамжийг цахим систем /QPAY/-ээр төлөх боломжийг бүрдүүлэх		машинаар дамжуулан газартай холбоотой үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан хураамжийг /QPAY/-ээр авч ажиллаж байна.	
Долоо. Хяналт шалгалтын чиглэлээр				
7.1.	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд эзэмшүүлэх, ашиглуулах газрыг нэгж талбар бүрээр нарийвчлан төлөвлөж зурагт оруулах, мөн ойн сан болон усны сан бүхий газрын төлөвлөлтөд анхаарч ажиллах, ГЗБТ-д тусгахгүй, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмыг баримтлахгүйгээр дуудлага худалдааны анхны үнээр тооцсон газрын үнийг төсөвт төвлөрүүлж газар олгодог зөрчлийг арилгах, таслан зогсоох		Тухайн онд эзэмшүүлэх, ашиглуулах газрыг нэгж талбар бүрээр төлөвлөж зурагт оруулж байгаа ба Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр ерөнхий газар хянаж Засгийн газрын тогтоолоор баталжаажуулснаар хэрэгжих боломж бүрдсэнээр ойн болон усны сан, инженерийн шугам сүлжээ бүхий газар, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зөрчиж, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгүйгээр газар олгох зөрчил арилсан. Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр газар олгох зөрчил бүрэн арилсан байна.	100
7.2.	Тухайн жилийн ГЗБТ-д нэмэлт тодотгол хийх нэрийн доор тухайн жилд олгох газрын хэмжээг нэмэгдүүлж, газар олгодог зөрчлийг гаргахгүй байхад анхаарч ажиллах		Тухайн оны Газар зохион байгуулалтын төвлөгөөнд тодотгол хийх зөрчил бүрэн арилсан. Зайлшгүй шаардлагаар тодотгол хийх тохиолдолд Засгийн газрын тогтоол гаргуулж, үүний хүрээнд газар олгож байгаа.	100
7.3.	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг хүчингүй болгоход иргэн, хуулийн этгээдэд харилцан адилгүй үйлчилж, Монгол улсын Дээд шүүхээс Газрын тухай хуулийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор гаргасан 2008-03-31-ний өдрийн “Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай” 15 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах		Аймгийн төвийн Өлгий сумын ойжуулалтын зориулалтаар дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр олгосон, тухайн газрыг зориулалтын дагуу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зориулалтаар нь ашиглаагүй газруудыг хүчингүй болгох талаар Улсын байцаагчийн албан шаардлагын мөрөөр хүчингүй болгосон. Монгол улсын Дээд шүүхээс Газрын тухай хуулийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор гаргасан 2008-03-31-ний өдрийн “Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай” 15 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаж байна.	90
7.4.	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, газар эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгоход газар дээр нь судалгаа хийх, холбогдох баримт бичгийг хянаж		Өлгий сумын хэмжээнд ойжуулатын болон аж ахуйн зориулалтаар эзэмшиж байгаа газраа 2 жил дараалан гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй 32 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон. Үүнд газар дээр нь судалгаа	100

	үзэх, тухайн маргаан бүхий захиргааны актыг гаргахаас өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийг оролцуулан, захиргааны акт гаргахтай холбоотой сонсгох ажиллагаа явуулах, урьдчилсан байдлаар мэдэгдэж тайлбар, нотлох баримт гаргуулах, бодит нөхцөл байдлыг судлан, нягталж шалгах		хийх, холбогдох баримт бичгийг хянаж үзэх, тухайн маргаан бүхий захиргааны актыг гаргахаас өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийг оролцуулан, захиргааны акт гаргахтай холбоотой сонсгох ажиллагаа явуулах, урьдчилсан байдлаар мэдэгдэж тайлбар, нотлох баримт гаргуулах, бодит нөхцөл байдлыг судлан, нягталж шалгах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн.	
7.5.	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастр, геодези, зураг зүйн чиглэлээр илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангуулах		Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай, Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 5 удирдамжаар холбогдох хяналт шалгалтуудыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлуудыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтын танилцуулгыг Ерөнхий газрын холбогдох улсын ахлах байцаагчдад хүргүүлэн ажиллаж байна.	100
Найм. Мэдээллийн технологийн чиглэлээр				
8.1.	Салбарын мэдээлэл дамжуулах сүлжээний хэвийн найдвартай аюулгүй ажиллагааг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд шинээр олгосон “Гэр интернэт” төхөөрөмж болон нийт мэдээлэл дамжуулах сүлжээний хувийн, найдвартай, аюулгүй ажиллагааг ханган ажиллах		Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон сумдад ашиглаж байгаа “Гэр интернэт”-ийн төхөөрөмжийн судалгааг 01 дүгээр сарын 04-ний өдөр 08 дугаар албан тоотоор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. Мөн шинээр ГЗБГЗЗГ-аас ирсэн 16 ширхэг “Гэр интернэт”-ийн төхөөрөмжийг сумдын газрын даамлуудад 02-р сард хүлээлгэн өгч, хуучин 15 ширхэг “гэр интернэт”-ийн төхөөрөмжийг хурааж авсан. 2024 оны 05-р сарын 13-ний өдөр Алтай, Баяннуур, Улаанхус сумдын гэр интернэтдээ 3 хоногт өглөө, өдөр, оройн цагуудад хурдны тест хийж, төхөөрөмжийн хурдыг шалгаж, үр дүнгийн нь нэгтгэн ГЗБГЗЗЕГ-ын МТХ-ий инженер Ё.Ивээлтийн мэйл хаягт 05-р сарын 16-ний өдөр хүргүүлсэн. Алтанцөгц сумын газрын даамлын “Гэр интернэт”-ийн төхөөрөмж сар болгоны эцэст эрх нь хаагдаж холбогдох газарт залган мэдэгдэж нээлгэх хүртэл хэд хоног ажил	100

			хийх боломжгүй болдог байсныг, 09 дүгээр сараас эхлэн автоматаар сунгагддаг хэвийн ажиллагаанд оруулж засуулсан.	
Ес. Архивын баримт бүрдүүлэлтийн чиглэлээр				
9.1.	Архивын баримтыг хадгалах стандарт орчныг бүрдүүлэх, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, цахимжуулсан баримтыг Архивын цахим системд холбох, нэгж талбарын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж байгууллагын архивт татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах		Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газрын шинээр хэрэгжүүлж буй https://archive.gazar.gov.mn/ цахим архивт 100 хадгаламж нэгжийн баримтыг цахимжуулан архивласан. 13 Сумын өмчлөлийн газрын нэгж талбарын 1594 хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн архивд хүлээн авч хадагаламжийн нэгж үүсгэсэн байна.	100
Арав. Газрын бирж, үнэлгээ, төлбөрийн чиглэлээр				
10.1.	Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу цахимаар зохион байгуулж, нээлттэй, ил тод байх, тэгш, шударга оролцоог хангах		2020-2024 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр аймгийн хэмжээнд газрын биржийн цахим системээр дамжуулан нийт 475 байршил дээр газар эзэмшүүлэх эрхийн цахим дуудлага худалдаа зохион байгуулж орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй төгрөгийн орлого оруулсан. Мөн уг системээр “Малчдын хоршоонд” зориулан 10 нэгж талбар дээр газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж эзэмшүүлсэн болно.	100
10.2.	Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэлтэй хүчинтэй гэрээний тоогоор газрын төлбөрийн ногдуулалтыг тухай бүр үүсгэж, Татварын удирдлагын нэгдсэн системд илгээж байх		Газрын төлбөр, татварын удирдлагын нэгдсэн системээр дамжуулан нийт 14103 хүчинтэй гэрээнд газрын төлбөрийн 475 сая төгрөгийн нэхэмжлэлийг үүсгэж аймгийн татварын газар болон сумдын газрын даамал, татварын байцаагч нарт хүргүүлж, газрын төлбөрийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр жигд биелүүлж ажиллах талаар үүрэг даалгавар өгч ажиллаж байна. 2024 онд газрын төлбөрийн төлөвлөгөө 373 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд эхний 11 сарын байдлаар 365 сая төгрөг төвлөрч гүйцэтгэл нь 97%-тай байна.	100
10.3.	Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг тогтмол бүртгэж, Газрын үнэлгээний цахим системээр газрын масс үнэлгээг тооцох		Газрын зах зээлийн үнийн мэдээллийг Газрын үнэлгээний системд оруулах, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллгуудын өмчлөл, эзэмшилд байгаа газруудад шилжилт хөдөлгөөн хийх бүрт эрх шилжүүлэх гэрээний үндсэн дээр газрын зах зээлийн бодит	100

			үнийн мэдээг авч системд бүртгэн газрын масс үнэлгээг тооцоолж байна.	
--	--	--	---	--

Тайлагнасан:

Төсвийн шууд захирагч

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

/ Ж.Естай/

.....